



## ГЭМТЭЛ, СОГОГ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/110

Улаанбаатар хот

Коронавируст халдвар (ковид-19)-тай иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх түр орны тоог нэмэгдүүлэх тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 34 дүгээр зүйлийн 34.2.2, Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1, Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/377 дугаар тушаал, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 3.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (ковид-19)-тай иргэнд тусламж, үйлчилгээ үзүүлэх түр орыг эрчимт эмчилгээний 5, энгийн 15 нийт 20 ор болгон ажиллуулж, тухайн тасагт ажиллах сувилагч, тусгай мэргэжилтэн, эмнэлгийн ажилтны нэрсийг хавсралтаар баталсугай.
2. Коронавируст халдвар (Ковид-19)-ыг хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээний түр заавар, холбогдох тушаал, шийдвэрийн дагуу хянаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба (Б.Бат-Оргил)-д үүрэг болгосугай.
3. Коронавируст халдвар (ковид-19)-ын голомтын ариутгал, халдварын сэргийлэлтийг хангахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Халдварын сэргийлэлт хяналтын алба (Т.Сүхболд) -д хариуцуулсугай.
4. Тухайн тасагт ажиллах сувилагч, тусгай мэргэжилтнүүдэд ур чадварын нэмэгдэл 25 хувийн нэмэгдэл олгохыг Санхүү бүртгэлийн алба (Ц.Энхбаяр)-т зөвшөөрсүгэй.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2021 оны А/54 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Э.ГАЛБАДРАХ

258

Гэмтэл согог судлалын үндэсний төвийн  
Ерөнхий захирлын 2022 оны 0.1 сарын 01-ны  
... дугаар тушаалын хавсралт



**Ковид-19 тасагт ажиллах сувилагч, тусгай мэргэжилтэн,  
эмнэлгийн ажилтны нэрс**

- Ахлах сувилагч: Сэдбазар Бүрэнжаргал
- Сувилагч: Батбаяр Ууганбаяр  
Тилекберген Аймангүл  
Лхагвасүрэн Болорчимэг  
Нацаг Адарсүрэн  
Балжинням Болортуяа  
Нурдолда Кундыз
- Туслах сувилагч: Ганбаатар Алтантуяа
- Асрагч: Төмөрлуу Оюунтуяа  
Төмөрбаатар Дуламсүрэн  
Мягмар Оюунцэцэг